

2018 оны 4 сарын 30-дөрөн

Дугаар № 18/01

Улаанбаатар хот

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайландаа өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 18/13 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ**:

- Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-ийн гаргасан 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР

2018 оны 4. сарын 30-өдөр

Дугаар № 18/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Уйл ажиллагаа, эрх зүйн хорооны 2 тоот Дүгнэлтийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн Дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1.1 Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт *Компани нь зөвхөн “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ.* гэснийг *“Компанийн хараат болон охин компанийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ.* гэж өөрчлөх;
 - 1.2 Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт *“ТҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТҮЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТҮЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.* гэснийг *“ТҮЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 (гурав) жил байх бөгөөд ТҮЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.* гэж өөрчлөх;
 - 1.3 Дүрмийн 9 дүгээр зүйлд *“Дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлээр охин компани үүсгэн байгуулах, тууний Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх”* гэж 9.7.21 дэх заалтаар нэмж оруулах.
2. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлж холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР

2018 оны 7. сарын 30. өдөр

Дугаар № 18/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2018 оны 9 тоот Дүгнэлтийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг 3 жилийн хугацаатай сонгосугай. Үүнд:
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.1. Монгол улсын иргэн Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Бямбажав овогтой Ганбат;
 - 1.1.2. Монгол улсын иргэн Монгол Улсын Хөгжлийн банкны Дэд захирал бөгөөд Актив пассив, хөрөнгө удирдлагын газрын захирал Баяраа овогтой Чойжилжалбуу;
 - 1.1.3. Монгол улсын иргэн Улаанбаатар хотын банкны Зөвлөх Мягмар овогтой Мөнхбаатар;
 - 1.1.4. Монгол улсын иргэн Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал Лхагважав овогтой Гантөмөр;
 - 1.1.5. Монгол улсын иргэн “Ти Ди Би Капитал УЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Товуудорж овогтой Даваажав;
 - 1.1.6. Монгол улсын иргэн “МИК ОССК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Бадамхатан овогтой Гантулга.
 - 1.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 1.2.1 Монгол улсын иргэн МУИС-ийн Профессор Чулуундорж овогтой Хашчулуун;
 - 1.2.2 Монгол улсын иргэн Уул уурхай металлургын цогцолбор байгуулах төслийн Уидрдагч Энхбаяр овогтой Шижир;
 - 1.2.3 Монгол улсын иргэн Эдийн засаг бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Зөвлөх Чулуунцэрэн овогтой Отгочулуу.
2. “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид тус тус мэдэгдэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын албанд даалгасугай.



М.МОНХБААТАР



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 4. сарын 30. өдөр

Дугаар № 18/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын
2018 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “МИК Холдинг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2018 оны 5 тоот Дүгнэлт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООНЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг Хавсралтад заасны дагуу баталсугай.
2. Тогтоолын Хавсралтаар батлагдсан зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороонд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР